



АНГЛИД

Есүсийг дагаж байгаа нь



**ЛҮСИА, ВИВИ,
ЗАК НАРТАЙ
ТАНИЛЦААРАЙ!**



Тэдний тухай

НЭРС: Лүсиа 7 настай;
Виви 9 настай;
Зак 9 настай

АМЬДАРДАГ ГАЗАР:
Английн Херефордшир

ХЭЛ: Англи хэл

ЗОРИЛГО БА МӨРӨӨДӨЛ: Сайн найз байх (Лүсиа), Итгэлийн тунхгийг цээжлэх (Виви), бусад хүүхдэд спортоор хичээллэхэд нь туслах (Зак)

ГЭР БҮЛ: Зак, Лүсиа хоёр ах дүүс, харин Виви бол тэдний үеэл.



Тэд хэрхэн Есүсийг дагаж байгаа тухай

"Манай гэр бүл эмээ, өвөөтэйгөө нэг фермд амьдардаг. Хийх ажил их байдаг ч бид үйлчилж байхдаа сайхан мэдрэмж мэдэрдэг. Есүс биднийг үйлчлээсэй гэж хүсдэгийг бид мэднэ" гэж Лүсиа хэллээ.

"Бид эмээд одой морьдоо арчлахад нь тусалдаг. Бид тэднийг хөтлөн хээр бэлчээдэг. Бид морины хашааг цэвэрлэж, үс дэлийг нь самнаж, идээшлүүлж, усны хувинг нь усаар дүүргэдэг. Бид эмээдээ туслах дуртай" гэж Виви хуваалцав.

Зак бас үйлчлэх замаар Есүсийг дагадаг. "Манай элэнц өвөө гартаа хагалгаа хийлгэсэн юм. Тэр талбайгаа арчилж чадахааргүй байсан. Манай гэр бүлийнхэн, үеэл ах нар, өвөө эмээ бүгд түүнд өвс хадаж, хогийн ургамал түүж өгч тусалсан. Элэнц өвөө маань маш их баяртай байсан." ●

ЗУРАГ ЧИМЭГЭЛИЙГ ЛОСКИ СЭМЛЭЛ ДЭЙЖН



Та нар Есүсийг хэрхэн дагадаг вэ?

Есүсийг дагах олон арга зам бий. Та нар Түүнийг хэрхэн дагадаг вэ? Бидэнд хандан бичиж бас ярьж өгөөрэй!

Тэдний дуртай зүйлс

СУДРЫН ТҮҮХ:
Зак Есүсийн усан дээгүүр алхсан түүхэд дуртай.



ГАЗАР:
Лүсиа, Виви хоёр морьдтой хамт байх дуртай.



ЖИМС ЭСВЭЛ ХҮНСНИЙ НОГОО:
манго (Лүсиа), амтат төмс (Виви), брокколи (Зак)



ХИЧЭЭЛ:
Дүрслэх урлаг (Лүсиа, Виви хоёр), Түүх (Зак)



ӨНГӨ:
нил ягаан (Лүсиа), оюу номин (Виви), шар (Зак)